ВИДЕО МЭДЭЭ · 2022 оны 1-р сарын 28

Про подкаст №74 ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТАЛААР



УЕПГ-ын Олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн Ю.Ариунзаяа МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Практик сургалтын төвийн эрхлэгч, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор С.Болормаатай "Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын талаар" ярилцлаа.

- Хөдөлмөрийн хуулийн зорилт нь хөдөлмөрийн харилцааны зарчим, суурь хэм хэмжээг тогтоож, уг харилцаанд оролцогч талуудын үндсэн эрх, үүргийг тодорхойлж, тэдгээрийн хоорондын зохистой тэнцвэрт байдлыг хангахад оршино.

- Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд оролцогч дараах суурь зарчмыг баримталж, холбогдох үндсэн эрхийг эдэлнэ:

  - үл ялгаварлан гадуурхах;

  - хөдөлмөрлөх эрх чөлөөг баталгаажуулах, ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангагдах, цалин хөлс авах, амрах;

  - дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох;

- албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох;
- барьцаа хэрэглэхгүй байх;
- эвлэлдэн нэгдэх, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулах, ажилтан, ажил олгогч, тэдгээрийн төлөөлөгчдийн хоорондын харилцааг зохицуулах эрхийг хангах;
- шударга бус үйлдлийг хориглох;
- нийгмийн түншлэлийг хангах;
- хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах.

- Ажил олгогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд нь ажилд орох гэж байгаа хүнд гүйцэтгэх ажил үүрэг, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, цалин хөлсний талаар хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсэхээс өмнө танилцуулах үүрэгтэй.
- Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцож, хөдөлмөрийн гэрээ байгуулна.
- Хөдөлмөрийн гэрээнд ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг; ажил үүрэг гүйцэтгэх байршил; цалин хөлсний хэмжээ; хөдөлмөрийн нөхцөлийг заавал тусгана.

Видео: https://www.youtube.com/watch?v=B3mdDtcYH1s

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2334